| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 49,153,000    | 49,153,000    | 48,617,400    | 48,617,400       |
| 132001        | Орон нутгийн төсвөөс  | 49,153,000    | 49,153,000    | 48,617,400    | 48,617,400       |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                    | 500,000       | 500,000       | 500,000       | 500,000          |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                       | 500,000       | 500,000       | 500,000       | 500,000          |
| <b>61</b>     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>   | 1             | 1             | 1             | 1                |
| 610001        | Төсвийн байгууллага   | 1             | 1             | 1             | 1                |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>   | 78            | 78            | 78            | 78               |
| 620001        | Удирдах ажилтан   | 1             | 1             | 1             | 1                |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан   | 41            | 41            | 41            | 41               |
| 620003        | Үйлчлэх ажилтан   | 25            | 25            | 25            | 25               |
| 620004        | Гэрээт ажилтан  | 11            | 11            | 11            | 11               |
| <b>63</b>     | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДҮНДЖААР)</b>                       | 598           | 598           | 604           | 604              |
| <b>630</b>    | <b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>                | 598           | 598           | 604           | 604              |

|           |   |           |           |           |           |
|-----------|---|-----------|-----------|-----------|-----------|
| 630001    | Төрийн өмчит ЕБС                                      | 598       | 598       | 604       | 604       |
| <b>65</b> | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                            | <b>78</b> | <b>78</b> | <b>78</b> | <b>78</b> |
| 650005    | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 42        | 42        | 42        | 42        |
| 650009    | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)            | 25        | 25        | 25        | 25        |
| 650010    | Гэрээт ажилтан  | 11        | 11        | 11        | 11        |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он         | Гүйцэтгэл         |
|-------------|---|------------------|-------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>3,260,615</b> | <b>56,435,500</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>3,260,615</b> | <b>56,435,500</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>3,260,615</b> | <b>56,435,500</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | -                | 1,449,724         |
| 210105      | Гэрээт ажлын хөлс   | -                | 1,449,724         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>3,260,615</b> | <b>900,000</b>    |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 260,615          |                   |
| 210404      | Ном, хэвлэл   | 3,000,000        |                   |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | -                | 900,000           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | -                | 49,200,000        |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   |                  | 49,200,000        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | -                | 1,000,000         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | -                | 1,000,000         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | -                | 3,885,776         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | -                | 3,885,776         |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | -                | <b>3,429,900</b>  |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг  | -                | 3,429,900         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>3,260,615</b> | <b>56,435,500</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>3,260,615</b> | <b>56,435,500</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | -                | 49,200,000        |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000        |                   |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 260,615          |                   |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                |                  | 7,235,500         |

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг сургуулийн захирал Л.Тогтохбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын худалдан авалт, санхүүгийн программ хангамжийн ашиглалт, мал амьтдын тооллого хийх, худалдан авалттай холбоотой асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Мөст сумын ерөнхий боловсролын сургууль нь “хичээл сургалтыг чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлж суралцагчийн хөгжил төлөвшилд ахиц гаргах, сурлагын түвшинг ахиулах, үнэлгээ шинжилгээг бодитой болгох, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, сургалтын таатай орчныг бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох,
- Иргэн тодорхой хугацаанд мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бие даан суралцах замаар боловсрол, мэргэшлийн ур чадвараа байнга дээшлүүлэх,
- Үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгох,
- Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн боловсролын үнэлгээний, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлаас 1008403.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 10084.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 1406506.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 14065.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138781.9 мянган төгрөгөөр буюу 8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр, төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд                     | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт          |
|--|--------------------|--------------------|-------------------|
| Авлага                                     | 4,640.0            | 665.7              | (3,974.3)         |
| Бараа материал                             | 47,905.8           | 99,690.4           | 51,784.6          |
| Үндсэн хөрөнгө                             | 1,695,994.6        | 1,786,966.2        | 90,971.6          |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                  | <b>1,748,540.4</b> | <b>1,887,322.3</b> | <b>138,781.9</b>  |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>           | <b>15,230.1</b>    |                    | <b>(15,230.1)</b> |
| Цэвэр хөрөнгө, өмч                         | 1,733,310.3        | 1,887,322.3        | 154,012.0         |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> | <b>1,748,540.4</b> | <b>1,887,322.3</b> | <b>138,781.9</b>  |

Авлага дансны үлдэгдэл 665.7 мянган төгрөг болж 3974.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99690.4 мянган төгрөг болж 51784.6 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-наас үнэ төлбөргүйгээр кабинет, хичээлийн хэрэглэгдэхүүн ирснийг БҮТЭЗ-ийн дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

| №   | Үзүүлэлт                  | Дүн        |
|-----|---------------------------|------------|
| 1   | <b>Оны эхний үлдэгдэл</b> | 47,905.80  |
| 2   | Нэмэгдсэн                 | 120,733.60 |
| 2.1 | Худалдан авсан            | 79,106.00  |
| 2.2 | Хандиваар                 | 41,627.60  |
| 3   | Хасагдсан                 | 68,948.90  |
| 3.1 | Худалдсан, зарцуулсан     | 68,948.90  |
| 4   | <b>Эцсийн үлдэгдэл</b>    | 99,690.50  |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2522625.4 мянган төгрөг болж 17541.2 мянган төгрөгөөр өссөн нь тавилга эд хогшил, ном сурах бичгийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

| №   | Үзүүлэлт                                   | Дүн          |
|-----|--|--------------|
| 1   | <b>Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b> | 2,505,084.2  |
| 2   | Нэмэгдсэн                                  | 177,593.10   |
| 2.1 | Худалдан авсан                             | 49,200.0     |
| 2.2 | Хандиваар                                  | 128,393.1    |
| 3   | Хасагдсан                                  | 160,051.90   |
| 3.1 | Акталсан                                   | 160,051.90   |
| 4   | <b>Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>    | 2,522,625.4  |
| 6   | Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл | 809,089.60   |
| 801 | Элэгдлийн зардал тайлант хугацааны         | 86,157.90    |
|     | Дансны хасалт                              | 159,588.30   |
| 10  | Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл    | 735,659.20   |
| 11  | <b>Үлдэгдэл өртөг</b>                      | 1,786,966.20 |

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар ном, компьютер тоног төхөөрөмж, аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр дотуур байр болон гал тогооны их засвар, үнэ төлбөргүйгээр 177593.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийг аймаг, сумын ИТХ-ын 116, 64 тоот тогтоолоор 160051.9 мянган төгрөг данс бүртгэлээс акталж хасагдсан, биет бус хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл оны эхэнд 15230.1 мянган төгрөг, оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1887322.3 мянган төгрөг болж 138781.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн үр дүн данс руу 735.7 мянган төгрөгийн залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 154012.0 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 398103.6 мянган төгрөгөөр буюу 39.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй 27991.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан, бусад орлого 2905.6, хандив 40540.0, тусгай зориулалтын санхүүжилт 180363.2, ОНХС-аас 46200.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

| Үзүүлэлт                               | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт  |
|--|---------------------|-----------------------|-----------|
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b> | 1,008,403.2         | 1,406,506.8           | 398,103.6 |
| Туслах үйл ажиллагааны орлого          | 500.0               | 1,400.0               | 900.0     |

|   |           |             |           |
|---|-----------|-------------|-----------|
| Бусад орлого  |           | 2,905.6     | 2,905.6   |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                   | 1,676.6   | 129,667.6   | 127,991.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                            | 953,813.0 | 1,134,176.2 | 180,363.2 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 49,153.0  | 48,617.4    | (535.6)   |
| Хандив тусламжийн орлого  |           | 40,540.0    | 40,540.0  |
| Нэмэлт санхүүжилтийн орлого   | 260.6     |             | (260.6)   |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                             | 3,000.0   | 49,200.0    | 46,200.0  |

Нийт зардал өмнөх оноос 126918.7 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 152939.1, хангамж бараа материалын зардал 2611.9, эд хогшил, урсгал засварын зардал 1218.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 1173.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3054.5, нормативт зардал 40820.9, бараа үйлчилгээний бусад зардал 25265.1, мянган төгрөгөөр тус тус буурчээ.

| Дансны код                           | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт   |
|--------------------------------------|---|---------------------|-----------------------|------------|
| <b>2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b> |   | 1,125,112.4         | 1,252,031.1           | 126,918.7  |
| 2101                                 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                       | 763,726.2           | 899,620.0             | 135,893.8  |
| 2102                                 | Ажил олгогчоос даатгалд төлөх                           | 97,002.9            | 114,048.2             | 17,045.3   |
| 2103                                 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал               | 46,338.9            | 43,284.4              | (3,054.5)  |
| 2104                                 | Хангамж, бараа материалын зардал                        | 15,438.6            | 18,050.5              | 2,611.9    |
| 2105                                 | Нормативт зардал  | 60,591.1            | 19,770.2              | (40,820.9) |
| 2106                                 | Эд хогшил, урсгал засварын зардал                       | 853.9               | 2,071.9               | 1,218.0    |
| 2107                                 | Томиллолт, зочны зардал                                 | 306.6               | 306.6                 | -          |
| 2108                                 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 219.0               | 1,392.0               | 1,173.0    |
| 2109                                 | Бараа үйлчилгээний бусад зардал                         | 116,008.2           | 90,743.1              | (25,265.1) |
| 213                                  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | 24,627.0            | 62,744.2              | 38,117.2   |

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 735.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотой залруулга бичсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 833615.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 833615.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1183293.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1134176.2 мянган төгрөгийг тусгай шилжүүлгийн санхүүжилтээс, 48617.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1134176.2 мянган төгрөгийг тусгай шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 48617.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 500.0 мянган төгрөг, нийт 1183293.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл

ажиллагаанд 1134562.1 мянган төгрөгийг зарцуулж 48731.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1134562.1 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 14594.1, тогтмол зардал 1589.8, нормативт зардал 23122.6, урсгал шилжүүлэг 9425.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 48731.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ерөнхий боловсролын сургуулиуд хичээллээгүйгээс шалтгаалсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

| Хүснэгт 3 | Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт  | /мян.төг/       |
|-----------|-----------------------------------|-----------------|
| код       | хөтөлбөр, арга хэмжээ             | мөнгөн дүн      |
| 80101     | Үндсэн үйл ажиллагааны зардал     | 1,589.8         |
| 81801     | Үдийн цай хөтөлбөр                | 9,425.0         |
| 81806     | Дотуур байрны үйлчилгээ           | 25,425.2        |
| 80305     | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 1,095.8         |
| 81835     | Сургалтын хэвийн үйл ажиллагаа    | 11,195.7        |
|           | <b>ДҮН</b>                        | <b>48,731.5</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

УТХО-аар сургуулийн гал тогооны их засварын санхүүжилт 49200.0, багш ажилчдад худалдан борлуулсан махны үнэ 1905.6, Дэлхийн Байгаль хамгаалах сангаас уралдааны урамшуулал 1000.0, сурах бичгийн түрээсийн орлого 3429.9, туслах үйл ажиллагааны орлого 900.0 мянган төгрөг нийт 56435.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс сургуулийн гал тогооны засварын урьдчилгаа 49200.0, сурах бичгийн түрээсийн орлогыг БСШУСЯаманд 3429.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, малчны цалинд 1449.7, материалын үнэ 900.0, байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд 1000.0, нийт 55979.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 455.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 138 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 47 ажил гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитын тайлан, түүний зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, оны эцэст татан төвлөрүүлсэн ажил гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6906.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 11054.3 мянган төгрөгийн албан шаардлага, 22495.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 18.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |         | Зөрүү |          |      |
|-----------------|---------------------|----------|---------|---------|-------|----------|------|
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн     | Тоо   | Дүн      | Хувь |
| Акт             | 2                   | 6,906.7  | 1       | 5,042.7 | 1     | 1,864.0  | 73.0 |
| Албан шаардлага | 1                   | 11,054.3 |         |         | 1     | 11,054.3 |      |
| Зөвлөмж         | 5                   | 22,495.4 | 1       | 4,109.7 | 4     | 18,385.7 | 18.3 |
| Нийт дүн        | 8                   | 40,456.4 | 2       | 9,152.4 | 6     | 31,304.0 | 30,4 |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 129261.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 99583.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4673.3 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1 албан шаардлага, 25004.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Авлага 455.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
2. Дотуур байрны гал тогооны их засварын урьдчилгаанд 49200.0 мянган төгрөг олгож шууд зардлаар бүртгэсэн,
3. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 9306.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
4. Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 735.7 мянган төгрөгөөр бууруулаагүй,
5. Тайлант оны үр дүнг 39886.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасангай холбоотой залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 99583.8 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4673.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4673.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар тусгасан цалингийн урьдчилгаа, шатахууны авлагыг 2020 оны санхүүгийн тайланд шууд зардлаар бүртгэн, худалдан борлуулсан махны үнийг төлөөгүй нийт 4673.3 мянган төгрөгийг тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах

ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт бичих

2. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитын тайлан, түүний зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 47 ажил гүйлгээ, , оны эцэст татан төвлөрүүлсэн ажил гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр., 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэж заалттай нийцэхгүй, аудитын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 25004.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар түлээ нүүрс, аргалын худалдан авалт зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар шалгах асуудал байна.

**4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Санхүүгийн программ хангамж ашиглалттай холбоотой асуудал**

- 1.1. **Илрүүлэлт:** Нягтлан бодогч, эд хариуцагч нар холбогдох мэдээллийг санхүүгийн программд үнэн зөв, бүрэн оруулаагүйгээс аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүмүүс бүрээр авлага, өглөгийн тооцоог хаах боломжгүй, санхүүгийн тайлангийн уялдаагүй тайлагнадаг зөрчил илэрлээ.
- 1.2. **Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн программ ашиглалт хангалтгүй байх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.” гэж заасны дагуу санхүүгийн программд мэдээллийг үнэн зөв шивж оруулах,

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

**2. Мал амьтадтай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Тайлант онд байгууллагын данс бүртгэлд байгаа мал амьтдын тооллого хийгээгүй, санхүүгийн тайланд зөвхөн төлийг орлогоо бүртгэсэн, ашиг шим болон бусад тооцоо бодоогүй, багш ажилчдад худалдан борлуулсан махны үнийг цалингаас суутган авч нэмэлт данс руу шилжүүлж малчинд цалин олгосон зэрэг зөрчил илэрлээ.

**2.2. Эрсдэл:** Данс бүртгэлд байгаа мал дутах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарлага гаргах, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй байх

**2.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 7.7-д “Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий захирагчийн дансанд татан төвлөрүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Т өрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэсэн заалтуудыг мөрдөн мал амьтдын тооллого хийх, тооцоо бодож үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, , төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэн ажиллах

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

### 3. Худалдан авалттай холбоотой асуудал

**2.1. Илрүүлэлт:** Хүүхдийн хоол хүнсэнд шаардлагатай мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

**2.2. Эрсдэл:** Чанаргүй бүтээгдэхүүн худалдан авах, зах зээлийн үнэ ханшаас өндөр үнээр нийлүүлэх, худалдан аваагүй байх, материал бүрэн ирэхгүй байх,

**2.3. Өгсөн зөвлөмж :** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 6.4.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

|                              |                            |  |                     |
|------------------------------|----------------------------|--|---------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:               | <b>Мөст сумын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b> | Аудитын код:        |
| 2021                         |                            |  | ХОА-2021/33/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | <b>Мөст сумын сургууль</b> |  | Мянган төгрөгөөр    |

| №          | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                         |
|------------|--|------------|---------------------------------------|---|-------------------------|
|            |  |            | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                |
|            | 1  | 2          | 3                                     | 4   | 5                       |
| 1          | Нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн мөнгийг авлагаар бүртгээгүй орхигдуулсан  | 455.9      | Залруулга хийх                        | Сургуулийн захирал, нягтлан бодогч                | Л.Тогтохбаяр, П.Баянзул |
| 2          | Дотуур байрны гал тогооны их засварын зардлын урьдчилгаа олгосон, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн  | 49200.0    | Залруулга хийх                        |   |                         |
| 3          | Тайлан оны хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тусгасан   | 9306.0     | Залруулга хийх                        |   |                         |
| 4          | Тайлант онд хөрөнгө актлахдаа 2010 онд дахин үнэлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах бичилтийг орхигдуулсан  | 735.7      | Залруулга хийх                        |   |                         |
| 5          | Тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, өмнөх оны авлага, дахин үнэлгээний зөрүү өмнөх үр дүн рүү залруулаагүй орхигдуулсан  | 39886.2    | Залруулга хийх                        |   |                         |
| 6          | Өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар тусгасан цалингийн урьдчилгаа, шатахууны авлагыг 2020 оны санхүүгийн тайланд шууд зардлаар бүртгэн, худалдан борлуулсан махны үнийг төлүүлэн аваагүй, авлагаар тусгаагүй, ур чадварын нэмэгдлийг ажиллаагүй сард олгосон | 4673.3     | Төлбөрийн акт                         |   |                         |
| 7          | Хүүхдийн хоол хүнсэнд шаардлагатай мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авахад тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй                                     | 23098.7    | Зөвлөмж өгөх                          |   |                         |
| 8          | Санхүүгийн программд холбогдох дансны бичилтийг буруу хийж нягтлан бодогч нь авлага өглөгийг нарийн тооцоогүй шууд хааж тайлагнасан  |            | Зөвлөмж өгөх                          |   |                         |
| 9          | Багш ажилчдад худалдан борлуулсан махны үнийг цалингаас суутган авч нэмэлт данс руу шилжүүлж малчинд цалин олгосон, мал амьтдын тооллого хийх, тооцоо бодоогүй   | 1905.6     | Зөвлөмж өгөх                          |   |                         |
| 10         | Шилэн дансны хуульд заасан зарим мэдээллийг цахим сайтад байршуулаагүй   | 0          | Албан шаардлага                       |   |                         |
| <b>дүн</b> |  | 129261.5   |                                       |   |                         |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**